# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 13 өдөр Дугаар А/26

Улаанбаатар хот

**Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын албаны эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансат шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2025 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 1 д үгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 42,229,900.00 (дөчин хоёр сая хоёр зуун хорин есөн мянга есөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны балансат шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн ажлын алба (М.Мөнгөншагай)-нд зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Б.Батбямба)-нд даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

1425030059

ᠬᠠᠶᠢᠭ
ᠳ. ᠪᠣᠯᠣᠷ

I. Oyuunaa

(᠑᠐.ᠰᠠᠷ)-ᠪᠠᠷ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

(᠖.᠐᠐᠐᠐᠐᠐᠐᠐) — ᠪᠠᠷ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

(ᠲᠦᠭᠷᠢᠭ) 00.000.999.96

[illegible]

᠒᠐᠒᠒ ᠣᠨ ᠤ ᠑᠐ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠖ ᠤ ᠡᠳᠦᠷ

᠐᠕-᠙᠗

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/26 дугаар тушаалын хавсралт

# Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын алба

| № | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон он | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлэн авах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өнгөт принтер /Epson L805/ | 2020.12.31 | ш | 1 | 1,059,900.00 | 1,059,900.00 | 1,059,900.00 | 0.00 | |
| 2 | 128gb 300 mbs SD+Card reader | 2022.11.21 | ш | 1 | 800,000.00 | 800,000.00 | 416,666.75 | 383,333.25 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| 3 | Nikon D850 body /аппарат/ | 2022.11.21 | ш | 1 | 10,500,000.00 | 10,500,000.00 | 5,468,750.00 | 5,031,250.00 | |
| 4 | Nikon SB-910 Speedligth /гэрэл/ | 2022.11.21 | ш | 1 | 1,900,000.00 | 1,900,000.00 | 989,583.25 | 910,416.75 | |
| 5 | Nikon 16-35mm f4 дуран | 2022.11.29 | ш | 1 | 3,900,000.00 | 3,900,000.00 | 2,031,250.00 | 1,868,750.00 | |
| 6 | Nikon 70-200mm f2.8 дуран | 2022.11.29 | ш | 1 | 7,950,000.00 | 7,950,000.00 | 4,140,625.00 | 3,809,375.00 | |
| 7 | Nikon 24-120 | 2022.11.21 | ш | 1 | 3,800,000.00 | 3,800,000.00 | 1,979,166.75 | 1,820,833.25 | |
| 8 | Камерний хөл | 2020.12.31 | ш | 1 | 550,000.00 | 550,000.00 | 550,000.00 | 0.00 | |
| 9 | Сони камер | 2020.12.31 | ш | 1 | 6,050,000.00 | 6,050,000.00 | 6,050,000.00 | 0.00 | |
| 10 | Canon RP24-105mm STM | 2022.11.29 | ш | 1 | 5,280,000.00 | 5,280,000.00 | 2,750,000.00 | 2,530,000.00 | |
| 11 | Camera tripod WF717 хөл | 2022.01.01 | ш | 1 | 440,000.00 | 440,000.00 | 440,000.00 | 0.00 | |
| | | | | 11 | **42,229,900.00** | **42,229,900.00** | **25,875,941.75** | **16,353,958.25** | |